



**БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 1/15

Хөхбүрд

**Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан  
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр 9.6 дугаар заалт, Монгол Улсын Засгийн газрын “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” 2018 оны 225 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 25 өдрийн А/124 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын арга хэмжээг 2026 оны 03 дугаар сарын 01-ний 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл технологит хугацаанд зохион байгуулсугай.

2.Мал, эмнэлгийн ерөнхий газраас баталсан төлөвлөгөөний дагуу малын дархлаажуулалтын ажлыг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний аж ахуйн нэгжийн эмч нарт даалгасугай.

3.Сумын хэмжээнд дархлаажуулалт ажлыг хийснээс хойш 28 хоногийн хугацаанд тухайн мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтаар хэрэглэх, зах зээлд гаргаж борлуулах, нөөц бүрдүүлэхийг хориглосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Гансүх)-д даалгасугай.

ДАРГА  БЯМБАДОРЖ



642501365

